

Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын үүслийг тогтоох асуудалд

Дамдинсүрэнгийн Лхагвасүрэн ✉ 

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ lkha.opera@gmail.com

Дашдондогийн Батсайхан 

Соёл урлагийн их сургуулийн Театрын урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: 1931 онд байгуулагдсан Улсын төв театр бол ший жүжгийн буюу драмын театр байв. 1943 оноос тус театрыг Улсын Хөгжимт драматик театр гэж нэрлэсэн. 1963 онд тус театрыг Опер-балетын театр, Драмын театр гэсэн мэргэжлийн хоёр театр болгон шинээр байгуулах нам засгийн шийдвэр гарч бие даасан хоёр театр болж салжээ. Одоогийн Улсын Дуурь бүжгийн эрдмийн театр 1963 оноос насжилтаа тоолж ирсэн нь учир дутагдалтай хэрэг. Харин Хөгжмийн театр үүссэн 1943 оноос насжилтаа тооцож эхлэх нь үндэслэлтэй, түүхэн ач холбогдолтой.

Түлхүүр үгс: *хөгжмийн театр, театрын төрсөн өдөр, опер балетын театр*

On the issue of establishing the origins of the State Academic Opera and Ballet Theater

Damdinsuren Lkhagvasuren ✉ 

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ lkha.opera@gmail.com

Batsaikhan Dashdondog 

School of Theater Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The State Central Theater, founded in 1931, was a traditional drama theater. In 1943, the theater was renamed the State Musical Drama Theater. In 1963, the party and government decided to reorganize the theater into two new professional theaters: the Opera and Ballet Theater and the Drama Theater, and the theater was divided into two independent theaters. The current Academic Opera and Ballet Theater (ADBOT) has been counting its age since 1963, which is a mistake. However, it is

reasonable and historically significant to start counting its age from 1943, when the Musical Theater was founded.

Keywords: *musical theater, theater birthday, opera and ballet theater*

Оршил

Улсын Дуурь бүжгийн эрдмийн театр /УДБЭТ/ байгуулагдсан эхлэлийг “... Улсын Хөгжимт драмын театрыг 1963 оны 5 дугаар сарын 15-аас эхлэн дуурь-бүжгийн улсын театр, улсын драмын театр болгон хувааж бие даасан хоёр театр болгосугай...” гэж заасан МАХН ТХ, СнЗ-ийн 1963-5-10 өдрийн 132/182 тоот тогтоолыг үндэслэн 1993 онд театрын 30 жилийн ойг анх тэмдэглэн, саяхан 2023 онд 60 жилийн ойг тэмдэглэв. Эндээс үзвэл Монгол Улсад Драмын театрын урлаг нь 1931 оноос эхлэн хөгжиж, харин хөгжмийн театрын урлаг нь 1963 оноос анхлан үүсэж хөгжиж иржээ гэсэн ташаа ойлголтод хүрэх болно. Энэ нь УДБЭТ-ын түүхэн хөгжлийн 1963 оноос өмнөх бүхэл бүтэн үеийг үгүйсгэж, манай улсын орчин үеийн мэргэжлийн хөгжмийн урлагийн үндэслэгчдийн түүхийг эзэнгүйдүүлж байгаа юм.

Анх театрын урлаг үүсэх түүхэн угтвар болсон, Сүхбаатарын нэрэмжит клуб, Ардын цэнгэлдэх хүрээлэнд С.Буяаннэмэх, Ши.Аюуш болон жүжигчдийн хамт М.Дугаржав Д.Ишдулам, О.Дашдэлэг нарын хөгжмийн суутнууд хамтдаа Улсын төв театрыг байгуулахад оролцож жүжиг анги, дуу хөгжмийн ангиудад хамрагдаж ирсэн түүхтэй. Төв театрыг анх байгуулахад “...хэд хэдэн удаагийн шалгалт явуулж Ц.Гомбожав, Д.Намдаг, Д.Бат-очир, М.Лувсанжамц, Лувсандамдин, Л.Содном, Д.Цэрэндулам, Сосорбарам, Ч.Цэвээн, Б.Жигмиддорж, Л.Дамдинбазар, Ч.Лувсансодном, Л.Цэндсүрэн, Д.Мажаа нарын жүжигчин болох хүсэлтэй хүмүүс тэнцэж, хуучин ажиллаж байсан хөгжимчин Д.Ишдулам, О.Дашдэлэг, Г.Нацаг, Ю.Цэрэндорж, Раднаабазар /комиссар/, Д.Түдэв, С.Түвдэн, Л.Маам, лимбич Л.Цэрэндорж нар үлджээ...” (Оюун 1989, 92) гэж тэмдэглэжээ.

2018 онд “УДБЭТ-ын гарал үүсэл, хөгжил” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж “тус театрын насжилтыг 1963 оноос тоолох нь театрын түүхэн хөгжлийн нэг хэсгийг орхигдуулж байна гээд 1950 оноос театрын барилга ашиглалтад орсон цагаас тоолох нь зүйтэй” (Ц.Төвшинтөгс 2018, 29) гэсэн санааг театрын дарга Ц.Төвшинтөгс хөндөж, театрынхаа логонд “1950” гэсэн тэмдэглэгээ оруулжээ.

Энэ хурал дээр театр судлаач доктор, профессор Д.Батсайхан “...1940-1950 онд УДБЭТ-ын суурь тавигдсан. “Хөгжимт театр” хэмээх театр нь бүрэн сонгодог утгаараа 1963 оноос хойш хөгжиж ирсэн...” (Батсайхан 2018, 23) гэж тэмдэглэсэн байна.

Нэг дэх нь цаг хугацааг урагшлуулж тодорхойлсноороо дэвшилттэй ч түүхэн үндэслэлгүй буруу дүгнэлт, харин хоёр дахь нь хэдийгээр үнэнд ойр боловч тодорхой он цагийг дурдаагүйгээрээ дулимаг дүгнэлт юм.

1943 онд Улсын Төв театрыг “Хөгжимт драматик театр” нэрлэсэн түүхэн ач холбогдлыг онцгойлж авч үзвэл, театрын нэрийг зөвхөн өөрчилсөн биш, цоо шинэ хөгжмийн театр байгуулагдсан гэж үзэх нь зөв болов уу. Харин судлаачид театрын нэрийг өөрчилсөн хэрэг гэж харж иржээ. Гэвч театрын нэр өөрчлөгдсөнөөр бүтэц

зохион байгуулалтыг нь өргөтгөж, жүжиг анги, опер балетын групп гэсэн зохион байгуулалтад орж ажилласныг анхаарч үзсэнгүй.

Хөгжмийн театр буюу Улсын Дуурь балетын театрын үүслийг чухам хэдэн оны хэдэн сарын өдрөөс эхлэн тооцож болохыг тогтоох зорилго тавин судалгааг хийв.

Судалгааны арга зүй

Театрын түүхтэй холбоотой хэвлэгдсэн ном зохиолуудад хөгжмийн театрыг хэзээнээс байгуулагдсаныг тэмдэглэснийг эрж тогтоохыг зорьж, дурдатгал, нийтлэл, мэдээллүүдийг үндэслэн Улсын төв архив дахь Төв театр, Хөгжимт драмын театр, Урлагийн хэрэг эрхлэх газар, Соёлын яам, МАХН-ын Төв хороо, Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрүүдийн сан хөмрөг, хадгаламжийн нэгж дэх баримтуудад тулгуурлан нэгтгэн дүгнэх аргаар судалгааг хийв. Мөн дэлхийн театрын түүх, Зөвлөлтийн театрын түүхүүдийг судалж, харьцуулалт хийлээ.

Судалгааны үр дүн

Ардын хувьсгалын дараа 1922 оноос нам, эвлэлийн үүрүүдийн дэргэд бичиг үсэг, биеийн тамир, дуу хөгжмийн дугуйлангууд хичээллэж, ший жүжиг, концерт, үдэшлэг зохиодог дугуйлан, клубүүд бий болж, хувьсгалт сайн дурын уран сайхны идэвхтэй үйл ажиллагаа өрнөв. Үүний нэг нь Намын Төв хорооны намын үүрийн дэргэдэх “Сүхбаатарын нэрэмжит” клуб юм. Энэ клубийг жанжин Д.Сүхбаатар нас эцэслэсний дараахан 1925 оны 2 сарын 07-нд түүний нэрэмжит болгожээ. Энэ клубийн үйл ажиллагаанд Сүхбаатар өөрөө оролцож байсан, тус клуб нь Намын Төв хорооны байшинд байрладаг байсан учир ингэж нэрлэсэн байна. Харин энэ клуб нь одоогийн “Жанжин клуб” гэж нэрлээд буй Амгалангийн соёлын ордонтой огт хамаагүй бөгөөд нэрлэлээс нь болоод үйл ажиллагааг нь хольж, эх үүсвэр, уран бүтээлчдийг нь хутгасан түүх (Бурмаа 2013) байгааг залруулах хэрэгтэй юм. Амгаланд байгаа “Жанжин клуб” нь 1926 онд байгуулагдсан “Үлгэр жишээ клуб” (ҮТА 348-1-34) бөгөөд 1934 онд “Жанжин Сүхбаатарын нэрэмжит клуб” гэсэн нэрийг авчээ. “Үлгэр жишээ клубийн” тухай “Үндэсний соёлын зам” сэтгүүлийн анхны дугаарт дэлгэрэнгүй бичсэн бий.

1927 онд олноо “Бөмбөгөр ногоон” гэж алдаршсан барилгыг барьж, тэнд Сүхбаатарын нэрэмжит клубийн уран сайханчдыг орон тоогоор ажиллуулж, “Ардын цэнгэлдэх хүрээлэн” гэж нэрлэсэн монголын анхны урлагийн байгууллага байгуулагдав. Тус хүрээлэнд өөрсдөө ший жүжиг зохион тоглодог, мөн хятад жүжгүүдийг орчуулан тоглодог, мөн “Интернационал үдэшлэг” нэртэй концертын хөтөлбөртэй байжээ. Энэ нь сайн дурын уран сайханчдын түвшинд үйл ажиллагаа явуулдаг, тухайн үед хүрээнд байсан “Ши Юаньз” хэмээх хятад театр, оросын “Нардом”-д зохиогддог үйл ажиллагааг дуурайсан шинжтэй, тухайн үеийн урлагийн авьяаслаг хүмүүс цугларсан төв болж чадсан юм. Гэвч 1929 онд тоглох бүтээлгүй, уран чадварын хувьд мэргэжлийн ямар нэг чиг баримжаагүйгээс дампуурч уран бүтээлчид нь таржээ.

Төр засгаас урлаг уран сайхныг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, 1930 онд зөвлөлтийн мэргэжилтэн А.А.Ефремов Ардын гэгээрүүлэх яаманд сургагчаар уригдан ирж, ирсэн хойноо өөрийнхөө найруулагчийн мэргэжлээр Монголд театр

байгуулах хэрэгт шууд оролцохыг хүссэн нь дээд газраас зөвшөөрөгджээ (Намдаг 1988, 32). Тэрээр жүжигчний анхны түр сургууль байгуулж, бичиг үсэг, жүжигчний мэргэжлийн хичээл зааж төгсгөн, Ардын цэнгэлдэх хүрээлэнд байсан жүжигчдээр өргөтгөн, театр байгуулав. 1931 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын хэрэг эрхлэх хорооны 50 дугаар хурлаар “Ардын цэнгэлдэх хүрээлэн ба театрын ажлыг чанаржуулан байгуулах тухай” тогтоол гарч Улсын Төв театр гэж нэрлэв. Энэ бол Станиславскийн зарчим дээр тулгуурласан драмын театр байсан бөгөөд одоогийн Улсын Драммын эрдмийн театр энэ түүхэн цаг хугацааг өвлөн ирсэн юм.

1935 онд Төв театрын 4 жил, Ардын цэнгэлдэх хүрээлэнгийн 15 жилийн ойг улс даяар өргөн тэмдэглэж, театрын нэр хүнд, уран бүтээлийн хувьд тухайн үеийн хөгжлийнхөө оргилд хүрч, төрөөс театрт хандах хандлага ч эерэг болж, театрыг “Аж үйлдвэрийн гавьяаны нэгдүгээр зэргийн одон”-оор, нэр бүхий 11 уран бүтээлчийг одон медаль, “Алдарт гавьяат уран зохиолч, дуучин, хөгжимчин” цолоор шагнажээ. Энэ үеэс нам засгийн зүгээс театрт өндөр ач холбогдол өгч, театрын урлаг хөгжих түүхэн нөхцөл бүрдэхийн зэрэгцээ театрыг үзэл суртлын зэвсэг болгон ашиглах эхлэл тавигдсан.

Баруунтан, зүүнтний нугалаа, тэр үеийн нам, засгийн алдаатай бодлогын нөлөөгөөр 1939 он гэхэд жүжгийн зохиолч, найруулагч, удирдагч, нэрт жүжигчид зэрэг шилдэг сэхээтнүүдийг улс төрийн хэрэгт хоморголон баривчилж, хилс хэрэг тохон тамлаж тэдний бүтээлүүд, пьез, дууны түүврүүдийг устгаж улмаар анхны драмын энэ театрыг дампууруулжээ.

1940 оноос зөвлөлтийн мэргэжилтнүүд, найруулагч Г.А.Уварова, зураач Н.Бельский, хөгжмийн багш Б.Ф.Смирнов, найрал дууны багш Ф.И.Клейшко, бүжгийн /балет/ багш Н.Кузнецова нар уригдан ирснээр театрт шинэчлэл хийгдэж эхлэв. Театрыг тухайн үед ЗХУ-д өргөн баримталж байсан Хөгжимт драмын театрын хэлбэртэй болгох зорилт анхнаас нь тавьжээ. Уран бүтээлчдээр өргөтгөх, тэднийг мэргэжлийн төвшинд ажилладаг ур чадвартай болгох, дуучид, хөгжимчдэд ноот эзэмшүүлэх, цаашдаа хөгжимт драмын зэрэгцээ опер, балет тоглодог театр болгох зорилго тавьсан нь түүхэн баримтаас харагддаг. Үүний тулд үндэсний найрал хөгжмийг симфони найрал хөгжмийн бүрэлдэхүүнтэй болгож, мэргэжлийн найрал дууны /хор/ анги, балет анги, үйлдвэрлэл тайз, үзвэр үйлчилгээний ангиуд болгон өргөтгөн зохион байгуулжээ.

Баримт 1. 1943 оны 4 дүгээр сарын 24-нд МАХН-ын Төв хорооноос томилогдсон төлөөлөгчид Улаанбаатар хотын театр, цирк, клубүүдийн идэвхтэн, жүжигчид, хөгжимчдийн уулзалт хийж, уулзалт дээр Маршал Х.Чойбалсан “... Аливаа нэгэн театрт алсын хөгжих зам чиглэлт байх хэрэгтэй юм. Энэ чиглэлт нь манай театрт шаардагдаж байна. Энэ ямар зам байх ёстой юм бэ? Би бодож байна. Дуулдаг, хөгжимддөг, ярьдаг тийм уран сайхны театр байдаг. Ийм театр болбол зохино. Өөрөөр хэлбэл, хөгжим ба драмын театр хэрэгтэй гэж бодно. Харин дан ганц балет ба оперын театруудыг байгуулах нь арай эрт байна. Одоогийн театрын нэрийг ийм болгох хэрэгтэй байна” хэмээгээд цаашдын уран бүтээлийн чиг хандлага, уран бүтээлчдийг хамгаалах талаар өөрийн саналаа илэрхийлсэн байна. Үүний дараа 1944 оны 1 дүгээр сараас театрыг “Одон тэмдэгт Хөгжимт драматик театр” гэж нэрлэсэн албан бичгийн бланк хэрэглэх болсон бөгөөд төр засгаас

театрын нэрийг шинэчлэх тухай ямар нэгэн тогтоол шийдвэр одоогоор олоогүй байна. Ингэж Улсын төв театрын нэрийг Хөгжимт драматик театр гэж өөрчилсөн нь үйл ажиллагааны чиглэл төдийгүй бодлогын шинэ театр буюу хөгжмийн театр болгосон хэрэг гэж үзнэ. Энэ үеэс эхлэн театрын “Драм&Хөгжим” гэсэн хөгжлийн бодлого “Хөгжим&Драм” гэсэн хандлага чиглэлтэй болжээ.

Баримт 2. 33/1943/ оны 11 дүгээр сарын 15. Рапорт (УТА 13-1-76) № 48-69. Уран сайхны хэрэг эрхлэх газрын даргаас Намын Төв хорооны хоёрдугаар нарийн бичгийн дарга Сүрэнжав танаа чухалчлан хүсэх нь гээд Уран сайхны хэрэг эрхлэх газрын даргыг Ёндонжамц Улсын төв театрын дарга Ламжав гэсэн гарын үсэг бүхий албан бичиг юм. Уг баримтад “...театрын уран сайхны ажлыг улам бүр хөгжүүлэхийн тулд доор дурдсан арга хэмжээг авч өгөх. Үүнд:

1. Тус театрыг хөгжмийн драмын театр болгож драмын буюу опер жүжгийг талбихад манай жүжигчин, хөгжимчин, дуучин нар нь хамгийн цөөхөн доорд хэмжээнд байна. Жишээлбэл, одоо жүжигчин дөнгөж 40 гаруй, хөгжимчин 25, дуучин 4 буй нь нэгэн том жүжиг талбих хэмээхэд хүний хүчний талаар хүрэлцэхгүй нэг жүжигчинд хэд хэдэн давхар роль ногдуулах учраас жүжгийн чанар ба тоглолтын байдал сул дорой болж баймой. Ийм учраас тус театрын чанагшдын хөгжилд ба уран сайхны чанарыг эрс дээшлүүлэхэд эрхбиш хүчийг нэмэгдүүлэх нь манай ажлын шаардлагаас зайлшгүй болсон хэрэг тул энэ ирэх 44 онд танцын анги, голлогч дуучин жүжигчдийн анги, нийтийн дууны ангиудыг байгуулж шинэ батлагдах төсөвт жүжигчин 70, хөгжимчин 50, дуучин 20, танцчин 20-ийг тус тус буй болгож өгөхийг туйлаас хүсмүй...

3....Тус театр дээр дурдсан анги группүүдэд одоогийн байгаа мэргэжилтнүүдийн дээр доор дурдсан чухал хэрэглэгдэх мэргэжилтнүүдийг зөвлөлтөөс урьж ирүүлэхийг хүсмүй. Үүнд: нийтийн дууны багш, голлогч дуучин, жүжигчний багш, концертын эрхлэгч-хөгжимчин, скрип хөгжмийн багш, найрал хөгжмийн багш-мэргэжилтэн, нүүр будагч мэргэжилтэн, танцын мэргэжилтэн, тайзны мэргэжилтэн, величин /виолончил/ модон ба төмөр хөгжмийн багш, цахилгаан гэрлийн жинхэнэ уран сайхны мэргэжилтэн, үлээдэг гуулин хөгжмийн багш, мэргэжилтэн, уран сайхны сургуульд тусгай мэргэжилтэн, сургагч эдгээрийг тус тус ирүүлэх нь манай театрын уран сайхны ажлыг хөгжүүлэхийн ганц үндэс нь мөн болой...

...Мөн тайз гэрлийн ажилчдын тоог нэмэгдүүлэх, жүжгийн хувцас, зургийн будаг материал нийлүүлэх тогтолцоо бий болгох, театрт машин олгох, театрын шинэ барилгыг буй болгох, Уран сайхны сургуулийн зохион байгуулалтыг өөрчлөн зохиох зэрэг тодорхой саналуудыг гаргаж ... Дээр дурдсан зохих арга хэмжээнүүд ба ажилчдын цалин хэрэглэлийг нэмэгдүүлж, аж амьдралыг нь сайжруулах явдалд хэрэглэгдэх мөнгөн төсвийг элбэг хүрэлцэхээр энэ ирэх 44 оны төсөвт баталж өгөхийг хамтаар гуймуй гэжээ... гэснээс үзвэл 1943 оноос нэрээ сольсон Хөгжимт драмын театр нь опер балетын театрын зарчмаар ажиллах зорилт тавигдсаны баталгаа нь болох болов уу.

Баримт 3. Мөн 1943 онд Буриад улсын Хөгжимт драмын театр айлчлан ирсэн нь монголчууд опер балетын урлагтай танилцжээ. Манай уран бүтээлчид дуурь, балетын бүтээл хийх урам зоригийг өргөж, “Хөгжимт драмын театр нь

хөгжимт драмын жүжиг, опер, балет тоглодог театр юм байна” гэсэн ойлголтыг бий болгосон. Энэ цаг үеэс театрын хөгжимчид буриадын театрын хөгжимчдөөр багшлуулан, симфони найрлын хөгжмийн зэмсэг эзэмшиж эхэлсэн байна.

Баримт 4. Улсын төв театрыг Хөгжимт драматик гэж нэрлэх болсон шалтгааныг театр судлаач С.Дашдондог: “1940-өөд оны эхэн үеэс зөвлөлтийн театрын туршлагаас суралцах явдлыг чухалчилж, Зөвлөлтийн Дундад Азийн Холбооны Бүгд Найрамдах зарим улсын театрууд хөгжимт драмын хэлбэрээр хөгжиж байсныг манайхан бодохдоо “театрын хөгжлийн ганц зөв зам” хэмээн үзэж, даган дуурайх хандлага баримталжээ” (Дашдондог 1993, 21) гэж тэмдэглэсэн байна.

Тэр үеийн театрын хөгжлийн хамгийн ойрын бодит жишээ нь Буриад-Монголын театр байв. “...1939 оны 12 дугаар сарын 20-нд Буриад-Монголын Автономит Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Улсын Төв гүйцэтгэх хорооны тэргүүлэгчид Үндэсний драмын театрыг Хөгжимт драмын театр болгон өөрчлөх тухай зарлиг гаргажээ. Энэ өдрийг тус улсын Дуурийн театрын төрсөн өдөр гэж үздэг” (Бурятский театр оперы и балета 2024) гэж түүхэндээ тэмдэглэсэн байна. Ийнхүү одоогийн Лениний одонт, Гомбын Цэдэнжавын нэрэмжит Буриад улсын дуурь балетын театр нь Хөгжимт драмын театр байгуулагдсан цагаасаа насжилтаа тооцдог ажээ.

Дээрх баримтууд нь одоогийн Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын үйл ажиллагааны эхлэлийг Хөгжмийн театр байгуулагдсан 1943 оноос эхлэн тооцох үндэслэл болж чадна гэж үзнэ.

Театрын зүгээс 1943 онд Намын Төв хороонд тавьсан асуудлуудын хариуг дөрвөн жилийн дараа тодорхой өгчээ. Үүнд: “Улсын Хөгжимт драматик театрын гарган үзүүлэх жүжгүүдийн төлөвлөгөө ба уран бүтээлийн ажиллагаа байдал ба түүнийг сайжруулах арга хэмжээний тухай” МАХН-ын Улс төрийн товчооны хурлаас гаргасан 1947 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 2 тогтоолын 8 дугаар зүйлд заахдаа “Театрын цаашдын хөгжил ба опер, балетын хэсгийг байгуулах бэлтгэл ажлыг хангах үүднээс сайн дурын уран сайхны ажилтны дотроос авьяастай аль сайн 20 хүнийг дуу концертын ангид ба 10 хүнийг балетын ангид шилэн авч театрт шилжүүлэн өгөхийг Урлагийн хэргийг эрхлэх газар, НТХ-ны шинэ хүчний хэлтэст үүрэг болгосугай” гэсэн нь Опер балетын театрын эхлэлийг тавьсан анхны шийдвэр байв.

Театрыг эрчимтэй шинэчлэх ажлын хүрээнд Уран сайхны сургуулийг өргөтгөж, Б.Дамдинсүрэн, Б.Смирнов нар “Шарай голын гурван хаан”, Мандухай цэцэн хатан” “Миний баясгалан” зэрэг драмын хөгжмийг бичиж, 1942 онд “Учиртай гурван толгой” дуулалт жүжгийг дуурь болгож, 1944 онд балет анги зохион байгуулагдаж, олон үндэстэн угсаатны бүжгээс бүрдсэн “балетын үдэшлэг” хөтөлбөр тоглож, 1946 онд үндэсний найрал хөгжим симфони найралд шилжиж “Симфони концерт” хөтөлбөр болон, Улсын 25 жилийн ойн концертыг тоглон, 1947 онд найрал дууны албан ёсны анги байгуулагдаж, найрал дуучдын концерт зэрэг шинэ хэлбэрийн уран бүтээлүүдийг гарган үзүүлж, театрт бие даасан опер балетын группийг байгуулж, найруулагч, ерөнхий удирдаачийг томилжээ.

1949 онд “Бөмбөгөр ногоон” театрын барилга галд өртөж том хохирол амссан нь театрын шинэ барилгыг яаралтай ашиглалтад оруулах, бүтэц зохион байгуулалт, орон тоог өргөтгөх боломж бий болгов.

1950 онд УХДТ шинэ барилгадаа орохдоо, 180 ажилтан, уран бүтээлчидтэй болтлоо өргөжиж, Б.Дамдинсүрэн, Ц.Дамдинсүрэн нар “Учиртай гурван толгой” дуурийг симфони найрал хөгжимд шинэчлэн бичиж /1949 онд бүх ноот, шатсан/, шинээр найруулан уг дуурийн 1000 дахь тоглолтоор театрын барилгын нээлтийг хийжээ. Энэ үйл явдал нь Монголд Улсад Опер балетын театр байгуулагдах цаг болсон шүү гэсэн маш том мэдэгдэл байсан бөгөөд харин Хөгжмийн театр байгуулагдсаныг эндээс эхлэн тооцох үндэслэлгүй төдийгүй “1950” тоог логонд байрлуулах зөвхөн байшингийн насыг илэрхийлсэн хэрэг юм.

УААА-ыг хөгжүүлэх 2 дугаар таван жилийн төлөвлөгөөнд Опер балетын театр байгуулах тухай төслийг тухайн үеийн театрын найруулагч байсан Л.Ванган 1951 онд боловсруулж, Намын Төв хорооны Улс төрийн товчоонд танилцуулан зөвшөөрүүлж чаджээ. Үүнд 180 орчим уран бүтээлчид, театрын мэргэжлийн ажилчдыг шинээр бэлтгэх тооцоо гарчээ.

МАХН Төв хорооны Улс төрийн товчооны 1952 оны 1 дүгээр сарын 26 өдрийн 9, 17 дугаар хурлын тогтоолоор үндэсний оперыг хөгжүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх, гадаадад сургах, дотоодоо мэргэжил дээшлүүлэх түүхэн шийдвэр гаргасан байна. Улмаар 1954 оны 11 дүгээр сарын 11-19-нд хуралдсан МАХН-ын XII дугаар их хурлаас “...Улсын Оперын театр ба Баян-Өлгий аймагт драмын театр байгуулсугай...” (*МАХН Төв хорооны тогтоол* 1954) гэсэн тогтоол гарчээ.

1947 оноос 1963 оны хооронд Опер балетын театрын нарийн мэргэжлийн 180 боловсон хүчин бэлтгэх ажлыг төр засгаас системтэйгээр зохион байгуулж, хөгжмийн зохиолч, удирдаач, гоцлол дуучид, балетын жүжигчид, хормейстр, балетмейстр, концертмейстр, тайз гэрэл, арын албаны гол мэргэжилтнүүдийг бэлтгэв. Харин театрын опер балетын группийн уран бүтээлчид 1963 онд “Учиртай гурван толгой”, “Үнэн”, Жаргалын зам”, “Хөхөө Намжил” зэрэг үндэсний дөрвөн дуурь, “Манай нэгдлийнхэн”, “Ганхуяг” хэмээх хоёр үндэсний балет “Бахчисарайн оргилолт булаг”, “Шурале” гэдэг сонгодог болон гадаадын балет бүхий урын сантай болсон байлаа.

1963 онд Улсын Хөгжимт драмын театрыг Опер балетын театр, драмын театр гэсэн бие даасан хоёр мэргэжлийн театр шинээр байгуулах түүхэн шийдвэр гарчээ.

Хэлэлцүүлэг

1931 онд Улсын төв театр байгуулагдсан, 1963 онд Хөгжимт драмын театрыг Опер балетын театр болгосон МАХН-ын Төв хороо, Сайд нарын зөвлөлийн шийдвэрүүдийг баримтлан театрын насыг тоолж ирсэн байна. Харин Хөгжимт драмын театр байгуулах тухай намын төрийн шийдвэр гараагүй учир цаг хугацааны хувьд тодорхойгүй явж иржээ. Тухайлбал, БНМАУ-ын соёлын түүхэнд Хөгжимт драмын театр байгуулсан тухай тодорхой тэмдэглэгдээгүйгээс гадна, сүүлийн үеийн судалгааны бүтээлүүд Б.Пунсалдуламын “Шинэ соёл Монголд төлөвшсөн түүх” номонд ... Монголын хөгжмийн урлагийн түүхэнд 1947 онд Төв театрыг Хөгжимт драмын театр болгон, симфони хөгжмийн ангийг байгуулсан нь дэлхийн сонгодог хөгжим хөгжихөд чухал үүрэг гүйцэтгэжээ... (Пунсалдулам 2018, 230) гэсэн бол ШУА Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс гаргасан “XX зууны түүх” номонд ... Дэлхийн II дайны үед Төв театрыг Хөгжимт драмын театр болгон

өргөтгөв. Тус театрт найрал дууны болон бүжгийн ангийг шинээр байгуулж, симфони найралтай дуулж бүжиглэх болов... (Ред. Чулуунбаатар 2022, 158) гэж тэмдэглэснээс үзвэл, Хөгжимт драмын театр гэж нэрлэсэн энэ түүхэн үйл явдлыг театрын нэрийг сольсон, өргөтгөсөн хэрэг гэж үзэж хөгжмийн театр байгуулагдлаа гэж тоож үзээгүй бололтой.

1940-өөд оноос Хөгжмийн театрын эх үүсвэрийг тооцож эхлэх хэрэгтэй гэсэн Д.Батсайхан багшийн санааг үндэслэн асуудал дэвшүүлж судалгааг явуулав. 1940-1945 оны архивын баримт дотор “Хөгжимт драмын театр байгуулсугай” гэсэн ямар нэг шийдвэр, баримт олоогүй бөгөөд харин 1943 оны 4 дүгээр сарын 24-нд МАХН-ын Төв хорооноос томилогдсон төлөөгчид Улаанбаатар хотын театр, цирк, клубүүдийн идэвхтэн, жүжигчид, хөгжимчдийн уулзалт хийж уулзалт дээр Маршал Х.Чойбалсангийн хэлсэн үгийг үндэслэн Улсын төв театрыг “Хөгжимт драматик театр” гэж нэрлэжээ гэсэн бусад судлаач эрдэмтдийн дүгнэлттэй санал нийлсэн ч энэ нь зөвхөн театрын нэрийг сольсон хэрэг биш, Монголын Хөгжмийн театр байгуулагджээ гээд, одоогийн Дуурь балетын театрын үүсэл Хөгжимт драмын театр гэж нэрлэсэн энэ цаг үеэр тодорхойлогдоно гэдгийг батлахыг зорьсон болно.

Дүгнэлт

1. УДБЭТ-ын түүхэн эхлэлийг 1963 оноос тооцвол, өнөөгийн Улсын Драмын эрдмийн театр мөн энэ өдөр байгуулагдсан байх ёстой.
2. Хөгжмийн театрын эхлэл тооллыг Маршал Х.Чойбалсангийн хэлсэн үг, Буриад-Монголын театрын жишээ, 1943 онд Намын Төв хороонд явуулсан рапорт зэргийг үндэслэн, 1943 оны 4 дүгээр сарын 24-ийг Монголын Хөгжмийн театр үүссэн буюу Опер балетын театрын төрсөн өдөр гэж үзэх үндэслэлтэй байна.
3. Судлаачид 1943 оныг Хөгжмийн театр байгуулагдсан цаг хугацаа гэж үзэлгүй зөвхөн театрын нэрийг нь сольж, “Хөгжимт драм” л тоглодог болж өргөжсөн хуучин Төв театр мэт дүгнэж иржээ хэмээн үзэж нэр солигдсоноор цоо шинэ Опер балетын театрын үндэс тавигдсан гэж дүгнэж байна.
4. 1963 оны 5 дугаар сарын 10 өдрийн МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 132/182 тоот тогтоолоор Улсын Хөгжимт драмын театр гэж нэрлэгдэж байсан нэг театрыг Опер балетын театр, драмын театр гэсэн хоёр мэргэжлийн театр болгосон юм.
5. УДБЭТ-ын түүхийг 1963 оноос эхлэн тоолох нь опер балетын мэргэжлийн театр байгуулах гэж амьдралаа зориулсан дуу хөгжим, найрал хөгжим, найрал дуу, балет анги, гоцлол дууны ангийн алтан үеийнхнийхээ хөдөлмөр зүтгэлийг үгүйсгэсэн хэрэг юм. Тухайлбал, Монголын Хөгжмийн театрыг үндэслэгчид болох М.Дугаржав, анхны хөгжмийн багш, удирдаач, хөгжмийн найруулагч Д.Ишдулам, хөгжимчин багш О.Дашдэлэг, анхны найрал дууны багш Ж.Дорждагва, анхны балетмейстер Ц.Раднаа, Лувсангунгаа, хөгжимчин багш Д.Түдэв, С.Түвдэн, Л.Маам, алдарт дуучин, багш Лувсангомпил (Чавганц багш), УГЖ дуучин Ц.Төмөр (Дөмөнгийн), Б.Нацаг (Нарийн хоолой), Ө.Лувсан (Хуурч), хөгжмийн зохиолч Б.Дамдинсүрэн, Л.Мөрдорж, Г.Жамьян, удирдаач Ж.Чулуун, Ц.Намсрайжав зэрэг алдартнуудын гавьяаг мартах эрх бидэнд байх ёсгүй.

6. 1943 оноос театрын үүслийн тооцож, “Хөгжмийн театр-Опер балетын театр” гэж үзвэл, өнөөгийн УДЭТ-ын мэргэжлийн ангиуд нь театраасаа “ах” настай явж ирсэн нэг гажиг тогтолцоо үгүй болно. Тухайлбал, хөгжим анги /1924/ 100 настай, найрал дуу /1947/ 77 настай, балет анги /1944/ 80 настай, гоцлол дууны анги /1952/ 72 настай хэмээн тооцож иржээ.
7. Одоогийн УДБЭТ нь орон нутгийн Хөгжимт драмын театруудын анхдагч, “Хөгжмийн театр” мөн.

Ашигласан материалын жагсаалт

- Болдбаатар, Ж., Хишигт, Н., Пунсалдулам, Б., Эрдэнэбат, Д., Батдорж, Ч. 2022. *XX зууны Монгол: боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн түүх*. Улаанбаатар: Удам соёл ХХК.
- Бурмаа, Х. 2012. *Монгол урлагийн ууган голомт Олноо алдаршсан Жанжин клуб*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Бурятский театр оперы и балета. 2024. “О театре.” <https://uuopera.ru/>. 2024.07.20. <https://uuopera.ru/about/>.
- Дашдондог, С. 1996. *Жаран жилийн шастир I, II боть*. Улаанбаатар: Сүхбаатар ХХК хэвлэлийн газар.
- Дашдондог, С., Эрдэнэбулган, Л. 1993. *Урлагийн ариун сүмийн мөргөлчдийн тухай тэмдэглэл*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо.
- Зориг, Б., Оюун, Э. 2018. *Монголын театрын түүх*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс.
- Лхагвасүрэн, Д. 2014. *Их урлагийнхны түүх, уран бүтээлийн товчоо*. Улаанбаатар: Чөлөөт хэвлэл сан.
- Лхагвасүрэн, Д. 2023. *Монголын хөгжмийн театрын түүхэн алдартнуудын товчоо*. Улаанбаатар.
- Лхагвасүрэн, Д. 2018. *УДБЭТ-ын гарал үүсэл, хөгжил /УДБЭТ-ын ЭШХ-ын илтгэлүүдийн эмхэтгэл*. Улаанбаатар.
- Намдаг, Д. 1988. *Шинэ Монголын шинэ театр*. Улаанбаатар: УХГ.
- Нацагдорж, Ш. 1986. *БНМАУ-ын соёлын түүх хоёрдугаар боть*. Улаанбаатар: УХГ.
- Оюун, Э. 1989. *Монголын театрын түүхэн замнал*. Улаанбаатар: УХГ.
- Пунсалдулам, Б. 2018. *Шинэ соёл Монголд төлөвшсөн түүх*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК.

Архивын материал:

Монгол Улсын Үндэсний төв архив /МУУТА. УТА ХН 1-1-36

Монгол Улсын Үндэсний төв архив /МУУТА. УТА ХН 13-1-76

Монгол Улсын Үндэсний төв архив /МУУТА. *Рапорт № 48-69*. УТА ХН 283-1-76

Монгол Улсын Үндэсний төв архив /МУУТА. *Үлгэр жишээ клуб*. УТА ХН 384-1-34.